

# Үнсний оронд гоёл чимэг: Уучлалын эдгээх зам



Олон жилийн турш, уучлалын зам дээр амар амгалан, эдгэрлийг олох гэж хичээж байхдаа би гэм нүглийг минь цагаатгасан Бурханы Хүү бол намайг ихээр гомдоосон хүмүүсийг ч мөн аврах тэрхүү Гэтэлгэгч юм байна гэдгийг илүү их ойлгох болсон. Өөрөөр хэлбэл, Гэтэлгэгч нүглийг минь цагаатгасан гэдэгт үнэхээр итгэж байгаа бол Гэтэлгэгч намайг гомдоосон хүмүүсийн нүглийг ч цагаатгасан гэдэгт итгэх ёстой байв.

Аврагчийг хайрлах тусам би гомдол, уур бухимдлаа Түүний эдгээх тосоор солихыг хүсэх болсон. Энэ нь олон жилийн үйл явц байсан бөгөөд эр зориг, эмзэг байдал, тэсвэр тэвчээр, Аврагчийн аварч, эдгээх бурханлаг хүчинд итгэж сурахыг шаардаж байв. Надад хийх зүйлс байгаа ч гэсэн зүрх сэтгэл минь тэмцлийн зам дээр байхаа больсон. Хажууд минь байж, эелдгээр мөн тэвчээртэйгээр илүү сайн газар луу намайг хөтөлж, надтай хамт уйлж, миний уй гашууг мэддэг Аврагчийн гүн гүнзгий, байнгын хайрыг мэдэрдэг “шинэ зүрх” [Езекиел 36:26] надад өгөгдсөн.

Ахлагч Ричард Г.Скотт “Чи болсон зүйлийг арилгаж чадахгүй ч уучилж чадна. Уучлал нь аймшигт, эмгэнэлт шархыг эдгээдэг, яагаад гэвэл энэ нь зүрх сэтгэл, оюун ухаанаас чинь үзэн ядалтын хорыг авч хаях боломжийг Бурханы хайранд олгодог. Энэ нь өшөө авах хүсэл бодлыг чинь цэвэрлэдэг. Энэ нь Их Эзэний ариутгагч, эдгээгч, сэргээгч хайранд зай тавьж өгдөг” гэж хэлсэн [“Healing the Tragic Scars of Abuse,” *Ensign*, 1992 оны 5-р сар, 33].

Сүүлийн жилүүдэд аавын минь зүрх сэтгэл ч гайхалтайгаар өөрчлөгдөж, Их Эзэнд хандсан. Би тийм зүйл энэ амьдралд болно гэж төсөөлж ч байгаагүй. Есүс Христийн бүрэн дүүрэн бөгөөд өөрчлөх хүч чадлын талаар өөр нэгэн гэрчлэл надад бий.

Тэрээр нүгэлтнийг болон нүгэл үйлдсэн хүмүүсийг эдгээж чадна гэдгийг би мэднэ. Тэр бол биднийг дахин амьдруулахын тулд амиа өгсөн дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч юм. Тэрээр “Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайн мэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь зовж шаналсныг эдгээх, олзлогдогсод эрх чөлөөг тунхаглах, сохруудад хараа оруулах, дарамтад байгсдыг чөлөөлөхийн тулд юм” [Лук 4:18; тодотгол нэмсэн] хэмээн хэлсэн.

Зовж шаналсан, олзлогдсон, дарамтад байгаа, магадгүй гомдол эсвэл гэм нүгэлд сохорсон бүх хүнд Тэрээр эдгэрэл, сэргээлт, чөлөөлөлтийг өгдөг. Түүний өгч буй эдгэрэл болоод сэргээлт бодитой гэдгийг би гэрчилж байна. Эдгэрэх цаг хугацаа хувь хүн бүрд өөр бөгөөд бид бусдын цаг хугацааг шүүж чадахгүй. Өөрсдийн эдгэрэлд шаардлагатай цагийг гаргаж, энэ үйл явцдаа өөрсдөдөө зөөлөн хандах нь чухал. Аврагч үргэлж нигүүлсэнгүй, халамжаар дүүрэн байж, бидэнд хэрэгтэй дэмжлэгийг үзүүлэхэд бэлэн байдаг.

Уучлал, эдгэрлийн зам дээр бид гэр бүлдээ эсвэл хаа нэгтээ эрүүл бус амьдралын хэв маяг, харилцааг зогсоох сонголтыг хийдэг. Бид нөлөөлж болохуйц хүмүүстээ харгислалын оронд нинжин сэтгэл, үзэн ядалтын оронд хайр, зөвүүцлийн оронд зөөлөн сэтгэл, гай зовлонгийн оронд аюулгүй байдал, сөргөлдөөний оронд амар амгаланг санал болгож чадна.

Өөрт байхгүй зүйлээ өгөх нь Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан боломжтой болдог бурханлаг эдгэрлийн хүчирхэг хэсэг юм. Исаиагийн хэлсэнчлэн, амьдралынхаа үнсний оронд гоёл чимгийг [Исаиа 61:3-ыг үзнэ үү] өгөх байдлаар амьдрах нь бүх хүмүүнийг халамжилж болохын тулд бүхнээ зориулсан Аврагчийн гайхалтай үлгэр жишээг дагаж буй итгэлийн үйлдэл юм.

Бидний Аврагч Есүс Христ гашуун зовлон дунд ч “Аав аа, тэднийг уучлаач; Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” [Лук 23:34] хэмээн хэлснээр хайр, уучлалын хамгийн агуу үлгэр жишээг үзүүлсэн билээ. (Кристин М.Еий, “Үнсний оронд гоёл чимэг: Уучлалын эдгээх зам,” *Лиакхона*, 2022 оны 10-р сар, 37–38)